

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Я.Гунаажав	Дугаар	L020
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Хан-Уул дүүрэг
Төрсөн газар	Говь- Алтай аймгийн Дэлгэр сум	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хүрхрээгийн хийд	Сүм хийдийн дугаар	ГАЧН 095
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	УВ 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Говь-Алтай аймгийн Чандмань сумын Хүрхрээгийн хийд

Миний нагац нар Чандмань сумын Хүрхрээ гэдэг хийдийнх. Тэд намайг таван настай байхад авч явж хийдэд суулгасан. Тэгээд 23 нас хүртлээ тэнд суусан. Хийдийн төвд нэр нь Дашчойнхорлин. Монголоор Хүрхрээгийн хийд гэдэг. Усныхаа нэрээр нэрлэгдсэн юм. Хийд Хүрхрээ голынхоо тэнд. Сумын төвөөсөө 40 орчим км зайтай. Тэр газар нь Засагт хан аймгийн тариалангийн талбай. Тэрийг түшиглэж байгуулагдсан газар. Бигэр тэр хоёр бол Засагт ханы бүр л тариалангийн газар юм. Хийд нь Хонзого ноёны хошуу. Манай хийд намайг сууж байхад хорь гучин жилийн түүх байсан байх. Уул нь энэ Богдын хүрээний Шүтээн аймгийн унзад Дондог гэдэг их дуутай лам байсан юм. Тэр хүн Богдод Батцагаан дуганд даншиг өргөхөд Шүтээн аймгийн унзад байж гарч, гарсан дөрвөн их унзадыг дуугаараа дарсан тийм их дуутай. Тэгээд Богд дуудаж аваачаад чи нэг тийм газар гэж эндээс

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хүрхрээг зааж өгсөөд хийд байгуул гэсэн. Тэгээд эндээс бадар барьж яваад Ламын гэгээнийд очиж. Ламын гэгээний дүү нь хүүхэд нь тогтдоггүй айл байсан. Авгай нь юу юугүй төрөх болсон үед очсон. Манай багш лам эх барьж авсан. Тэгээд тэдний хүүхдийг тогтоосон. Очиход чи Богдын хүрээний лам юм бол манай дүү жилийн нэг хүүхэд гаргаж үхүүлж байх юм. Тэрийг тогтоох арга байна уу гэсэн. Болох байлгүй дээ гэсэн. Тэгээд оччихоод Гомбо сахиус л уншсан юм гэнэ лээ. Тэр хүүхдийг нь тогтоож өгөөд, тэднийх нэг дээлийн хуй торго, тавин лан ембүү барьж гэнэ. Тэгээд л Ламын гэгээнийд дүү нь хүргээд ирсэн. За чи юу өгөв гэсэн. Тийм юм өглөө гэсэн. Хэдэн гунжин тэмээний хөлдөөд үхчихдэг ботго л байгаа биз. Чи энэ хийд байгуулах гэж байгаа хүнд 100 ачааны ат өг гэсэн. Өгсөн. Тэгээд орон майхан төхөөрүүлж нутагт нь хүргүүлсэн тэгж бүтсэн түүхтэй хийд юм гэнэ лээ. Тэр лам Богдын хүрээнд байж байгаад томчуулаа мэддэг. Чойжил гэлэн гэдэг нэг ян данд сайн хүнээ Засагт ханд өргөдөл бичиж байж татаж аваад. Бичээч гавж гэдэг бурхан зурдаг бас сайн эм барьдаг хүн. Намжил гэлэн гэж Богдын хүрээний да зурхайчийг, Чойрын ном мэддэг, нэрийн номд сайн Балдан гавж гэсэн дөрвөн хүнийг Засагт ханд өргөдөл өгч би энд хийд байгууллаа. Ингэхлээр Богдын хүрээнд таны харьяаны тийм тийм улс байна. Энийг татаж авчирч аль, та хан нь мөн юм бол гэсэн. Тэгээд Засагт хан Богдод бичиг явуулсан. Тэгсэн Богд зурхайч Намжилыг би мэдэхгүй. Богдын хүрээний ганц зурхайч. Халхын ганц зурхайч юм л даа. Бусдыг нь бол яахав. Шанзавын яамтай би энүүгээр нь ярилцъя гэсэн. Тэр үед Шанзавын яам мэддэг байсан юм байх. Тэгсэн ердөө Балдан гавж, Чойжил хоёрыг өгчихөөд наад хоёрыг нь өгсөнгүй гэнэ. Тэгсэн хан хүн юм бол манай хүнийг өг гэсэн өргөдөл бичээтэх би өрөө Шанзавын яаманд өгнө гэсэн. Тэгсэн Шанзавын яам тэр хоёрыг нь өгсөн. Тиймээс Хүрхрээгийн хийд уншлага сайтай. Зурхайд их сайн. Дуу сайтай байсан. Ямар сайндаа Засагт хан очоод маань татуулчихаад манай багшаас асуусан юм байна лээ. Яасан их дуутай лам нартай юм гэж. Тэгэлгүй яахав та энэ нэрлэсэн газрын усыг нь бод. Хүрхрээ гэдэг чинь голын дээд талын ус нь тийм их харгиатай түүгээрээ тийм их дуутай хүрээ байхгүй юу гэсэн юм гэнэ лээ.

300 гаруй ламтай. Манбын дуган, Чойрын дуган, Хайлангийн дуган, Цогчэн дуган гэсэн дөрвөн дугантай байсан. Тэгээд 1931 оны хамгийн эхний бариагаар том гэсэн 16 ламыг баривчилсан. Тэгээд бусад нь байшингийнхаа үүдийг онгойлгоод онгойлгож хаяад явчихсан. 150 орчим том лам байсан байх. Жижиг лам олонтой. Том лам нараас арваадхан лам л үлдсэн юм. Бусдыг нь хуу барьж аваачаад үгүй хийчихсэн.

Цогчэнгийн гол сахиус нь Лхам, Гомбо, Чойжоо. Чойр дуганых Сэндэм. Манлынх нь Шүг сахиус. Манай хийдэд Чандмань, Бигэр, Дэлгэрээс голчлон лам нар суудаг байсан.

Хийдийн тэргүүн нь анхан байгуулсан Дондог. Цогчэн цорж нь Балдан гавж гуай. Унзад нь Чойдог, Дагданбанжгай хоёр байсан. Гэсгүй нь Жаал гэсгүй, Ядамжав гэсгүй хоёр байсан. Жаал гэсгүйг хэн гэдэг байсныг мэдэхгүй. Би өөрөө Цогчэнд л хурж байсан болохоор бусад дуганыг мэдэхгүй. Тэгэхэд хүүхдүүд хамаагүй гүйхгүй. Хийдэд хоёрхон Жанчив чодун суварга Цогчэн дуганын хоёр талд байсан юм. Хийд дугануудаа тойрсон жижигхэн хашаатай. Лам нар нь хийдийн эргэн тойрон буучихсан байдаг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хурал номын хувьд Хүрээтэй яг адил. Тэр лам чинь Энд Шүтээн аймагт байсан болохоор яг адил. Дараа нь татаж авсан лам нар нь ч хүрээнийх болохоор Хүрээ дэгтэй байсан юм. Өдөр тутмын, сарын, жилийн, цагаан сарын бүх хурлууд Хүрээтэй адилхан хурна. Цам, Майдар байгаагүй. Ганжуурыг зуны эхэн сард сарын хугацаатай үсэгчлэн (бүтнээр нь) уншдаг газар байсан юм. Тэгээд сүүлд нь Ганжуураа үүрээд хүрээгээ тойроод гороо хийчихнэ. Залуучууд л явна. Өвгөн лам нар бол дуганаа л тойрно.

Нэг зүйл сонирхуулахад Дуутын хүрээнд сууж байсан Дамдинсүрэн маарамба баридаад оргоод Халтарын модонд нуугдаж бүгж байсан. Шавь нь багш Халтарын модноос өөр газар очихгүй гэж бодоод тийшээ очсон. Тэгсэн модны доор бууз байх юм гэнэ. Бүр махтай бууз. Тэгсэн шавь нь бодож гэнэ. Багш сая бууз чимхэж байгаад намайг ирэх чимээнээр нуугдлаа гэж. Тойроод явж байсан. Багш нь нэрээр нь дуудсан. Та хаана байна гэсэн. Энд байна гэхээр нь яваад очтол том мод хад хоёрын завсар байж байна гэнэ. Чи намайг энд байна гэж яаж мэдэв гэсэн. Энд бууз байна тэгэхээр нь ойр хавьд байна гээд яваад байлаа гэсэн. Ямар юмных нь бууз байхав дээ. Тэр бол уулзах л учир гаргасан. Би дөрвөн морь алдчихсан гээд өдөр болгон явж байгаа. Тэнд нэг асганд хүн нуугдаад байж болох агуй олсон. Та тэнд байж бай гээд аваачсан. Шавь нар нь хоол унд зөөж. Тэгээд л Гомбо сахиусаа тахиад байдаг байсан байгаа юм. Хүнд үзэгдэхгүй гэхээр үзэгддэггүй.

Дуганууд нь төвд маягийн дуган. Хайлангийн дуганыг хятад барьсан. Бусдыг нь монголчууд барьсан гэдэг. Хийдэд гавжийн дамжаа барьдаггүй байсан. Сүүлд домтой болсон. Чандмань суманд Гангатын дацан гэж байсан. Тэр Чойртой хийд байсан. Тэрийг Засагт ханы зарлигаар хураагаад манай хийд дээр авчраад манайх Чойртой болсон. Гэр дуган байсан. 12 ханатай гэр байсан байх. Дээгүүр нь яваад бүрээсийг нь тэнийлгэдэг байсан. Лам нар баригдсаны дараа гэрийг нь аймгийн төв рүү хураасан. Чойрын игчаа нь Сэра игчаатай байсан. Манай хийдэд Чойр дацан сүүлд байгуулагдсан. Ер нь хамгмйн анхных нь Цогчэн дуган. Тэгээд дараа нь Манба дацан. Тэгээд тэрний сүүлээр хэдэн гэлэн нь хайлан хийх гэж Хайлангийн дуган барьсан. Хамгийн сүүлд Чойр.

Манай хийдээс хойно Бигэр номун хааны хийд гэж байсан. Манайхыг бодвол дээр үеийнх байсан болохоор хэдэн дуган илүү байснаас тийм томгүй байсан.

Би уншлага төгсгөөд Чойрт хурахын даваан дээр хийд хаагдсан. Ердөө ганцхан Цогчэн жастай байсан. Их мал хөрөнгөтэй байсан. Лүйжинч, зоч нар байсан. Манай хамба багш чинь зод тавьдаг хүн байсан. Жил бүр л хоёр шавиа дуудаад жорзонд явуулдаг. Зодын тусгай дуган байгаагүй.

Тэр үед лам хүний өдөр тутмын амьдрал гэж хурлаа хурна. Номоо үзнэ. Өөр юм байхгүй. Манай хийд дээр эмэгтэй хүн хонохгүй. Ах дүү дээрээ ирсэн хүн гол дээр байсан тариа хардаг борчуудын гэрт очиж хонох жишээтэй. Сүсэгтнүүд хийдэд зундаа их ирнэ. Чандмань, Бигэр, Дэлгэр, Цогт энэ дөрвөн сумын дунд байгаа юм. Манай хийд дээр их ирдэг байсан юм. Хийдийн ойролцоо Сандаг гэдэг хятад, Лүүмүүз гээд нэг хятад пүүс байсан. Тэрнээс л юмаа авчдаг байсан. Нэг ламын хашаанд байшинг нь түрээсэлж байдаг. Намар зул сар оройхон явдаг, хавар эргээд ирдэг байсан. Тэмээ малаа хариулж байгаад ачаагаа ачаад явдаг байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

1931 оны зуны эхэн сараас лам нар нь баригдаад ерөөсөө нэг сарын дотор тараад алга болчихсон. Тэгээд хөдөө гарсан лам нарыг сүүлд нь түүгээд барьж аваад яваад байсан. Сүм дуганыг нь буулгаад сумын төв рүү модыг нь ачсан. Ном судар бурхан шүтээнийг шатаахыг нь шатаагаад хураахыг нь хураачихсан.

Би 23 настайдаа хар болсон. Цэрэгт явсан. Ахмад дайчин. Цэргээс халагдаад багийн даргаас өгсүүлээд хоршоо, аймгийн намын хороонд ажлаж байсан. Сүүлийн үед хотод орж ирээд Жанжин штабын 89-н гражд байж байгаад тэтгэвэртээ гарсан. 1990 оноос лам болж Дашчойлинд хурж эхэлсэн.

Цаашид Монголд бурханы шашин улам өргөн дэлгэр хөгжиж, ариун байж, лам нар сахил санваараа сайн сахиж байгаасай гэж боддог. Лам нар нь жинхэнэ гэлэн, гэцэл, аранжин сахилаа аваад лам хүний ёсоор эргэн дэгнэхгүй жинхэнэ лам байгаасай. Тэгвэл шажин сайхан болох юм. Урд чинь тэгж бөөн бөөнөөрөө явж ном сурч байгаагүй юм. Нэг хүн нэг үүрэг үүрээд тэгж явж очдог байсан. Одоо бол зөндөө явж байна. Хэн ном үзэх гэж санасан, хэн юм үзэх гэж санасан нь явдаг болж.

1992 онд Галсан гэдэг тэр хүрээндээ сууж байсан өвгөн нэг дуган барьж сэргээсэн. Хоёр гурван хүүхэд хурж байсан. Одоо байгаа байхгүйг мэдэхгүй.